

## ВЬЕТНАМ УЛС ТҮҮХЭН ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛИЙН 20 ЖИЛИЙН ЗАМНАЛД

*Б.Гантуяа\**

1980-аад оны дунд үеэс хуучин ЗХУ-аас Вьетнам улсад нийлүүлж байсан бензин, төмөр, бордоо, бөс бараа зэрэг 4 гол нэр төрлийн бүтээгдэхүүний хангамж огцом зогссон явдал Вьетнамын ард түмэн хүмүүнлэгийн болон эдийн засгийн хямралын хүнд хэцүү хэдэн жилийн нүүр үзсэн юм. Гар утас, мотоцикл, машин зэргийг хараахан мэдэхгүй байсан Вьетнамын ард түмэн нийгэм, эдийн засгийн хөгжлийн сэтгэлгээ болон практикийн шинэ сонголтын өмнө тулгарч ирээд байв. 1980-аад оны дунд үеэс эхлэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас нээлттэй, чөлөөт зах зээл эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжин орсноос хойш Вьетнам улс эдийн засгийн шинэчлэлийг эрчимтэй хийж, дэлхий нийтэд нээлттэй болж, эдийн засгаа либеральчилж, зах зээлийн харилцаанд эргэлт буцалтгүй шилжих шилжилтийг эхэлсэн юм.

Вьетнам улс 1987 онд “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуулийг анх баталж, 1990, 1992 онуудад дахин нэмэлт өөрчлөлт оруулсан<sup>1</sup>. 1987 оноос 1990 он хүртэл ПШХО голчлон судалгааны агуулгатай, жилдээ 1,1 тэрбум ам.доллар гадаадын хөрөнгө оруулалт бүртгэгдэж, үүнээс дөнгөж хэдэн зуун сая ам.долларын хөрөнгө оруулалт хэрэгжиж байв. 1991 онд Вьетнам улсад Гадаадын Хөрөнгө оруулагчдын анхдугаар Чуулган Хо Ши Мин хотноо зохион байгуулагдаж, шилжилтийн анхны давалгаа эхэлсэн бөгөөд 1991-1997 онууд бол гадаадын шууд хөрөнгө оруулалтын түүхийн алтан үе байсан гэж үзэж байна. Энэ үеэр, газрын тос, хийн салбарт үйл ажиллагаа явуулдаг “BP”, “Shell”, “Total”, машин, мотоциклийн үйлдвэрлэлийн салбарт “Daewoo”, “Toyota”, “Ford”, цахилгаан барааны үйлдвэрлэгч “Sony”, “Toshiba” зэрэг дэлхийн томоохон компаниуд Вьетнамын зах зээлд амжилттай нэвтэрч эхэлсэн. Гадаадын хөрөнгө оруулалтын хоёр дахь давалгаа 2006 оноос эдүгээ хүртэл эрч хүчтэй үргэлжилж байна. Энэхүү шинэчлэлийн хүрээнд, 1991 онд Вьетнам болон Хятадын эдийн засгийн харилцаанд ахиц гарч тогтвортой хөгжих боломж олгосон; 1994 онд Вьетнам, Америкийн харилцаа сэргэж, 2000 онд Вьетнам болон Америк хоёр улсын худалдааны гэрээ (ВТА) бий болсон; Вьетнам улс одоогоор аль нэг улстай худалдааны чөлөөт гэрээ байгуулаагүй байгаа боловч 1995 онд Вьетнам улс АСЕАН-ны гишүүн орноор элсэж, Вьетнам улс АСЕАН-аар дамжуулан АСЕАН-ы Худалдааны Чөлөөт Бүс (АФТА), АСЕАН-Хятадын Худалдааны Чөлөөт Бүс (АСФТА), АСЕАН-Өмнөд Солонгосын Худалдааны Чөлөөт Бүс (АКФТА) Гэрээг байгуулахад манлайлан оролцсон; түүнчлэн, АСЕАН-Японы Бүх талын түншлэлийн Гэрээ


\* Б.Гантуяа - БНСВУ-ын Ханой хотын Гадаад Худалдааны Их Сургуулийн докторант

(AJSER), АСЕАН-Австрали-Шинэ Зеланд болон АСЕАН-Энэтхэгийн Чөлөөт Худалдааны Гэрээ хэлэлцээрийг амжилттай хийж дуусгасан (2010 оны 1 дүгээр сараас албан ёсоор хэрэгжсэн); 1995 онд Европын Холбоотой харилцаагаа идэвхижүүлэн, Вьетнам-Европын Холбооны Хамтын ажиллагааны Гэрээнд гарын үсэг зурсан; 2007 онд Вьетнам улс ДХБ-ын албан ёсны гишүүнээр элссэн зэрэг түүхэн эдийн засгийн томоохон үйл явдлаар дүүрэн он жилүүд байлаа. Өдгөө Вьетнам улс Чөлөөт Худалдааны хэд хэдэн гэрээ хэлэлцээнд идэвхтэй оролцож байна, үүнд, Номхон далайн Эдийн засгийн стратегийн түншлэл, хамтын ажиллагааны Хэлэлцээр (*TPP - Trans-Pacific Strategic Economic Partnership Agreement*), АСЕАН-Европын Худалдааны Чөлөөт бүс байгуулах Гэрээ, Япон улстай Эдийн засгийн бүх талын түншлэлийн Хэлэлцээр, Вьетнам-Чили болон Вьетнам-Европын Холбооны хоёр талын Чөлөөт Худалдааны Хэлэлцээр зэрэг орж байна. Чөлөөт Худалдааны Хэлэлцээрийн хүрээнд хийгдэх Вьетнам улс гаалийн татварыг бууруулах, чөлөөлөх арга хэмжээнүүд 2020 он гэхэд дуусгавар болох юм. 2015 онд, Вьетнам улс АСЕАН-ы Бараа Худалдааны Хэлэлцээрийн дагуу (*ATIGA - ASEAN Trade in Goods Agreement*) АСЕАН-ы гишүүн улс орнуудтай, түүнчлэн, Чөлөөт Худалдааны Хэлэлцээрийн хүрээнд Хятад улстай; 2016 онд, Өмнөд Солонгос улстай; 2017 онд, Япон улстай, 2018 онд, Австрали, Шинэ Зеланд болон Энэтхэг улстай гаалийн татварыг дэс дараалан бууруулж тэглэх болно. Австрали, Шинэ Зеланд болон Вьетнам, Бруней, Мьянмар, Малайзи, Филиппин, Сингапур зэрэг АСЕАН-ы гишүүн улс орнууд 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 2020 оныг дуустал гаалийн татварыг 90-100 хувь болгон бууруулж тэглэх нэгдсэн шийдвэрт хүрч чаджээ<sup>2</sup>.

2011 оны 1 дүгээр сард, Вьетнам улсын Коммунист Намын 11 дүгээр Их хурал 1400 гаруй төлөөлөгчийн оролцоо бүхий амжилттай болж өндөрлөв. Тус хурлаар Вьетнамын Парламентын дарга Нгуен Фу Чонг ВКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргаар шинээр сонгогджээ.



Тус хурлаар Вьетнам улсын 2011-2020-аад оны Нийгэм, Эдийн засгийн хөгжлийн Стратегийг амжилттай баталсан болно. Энэ бол Вьетнам улс гаргаж буй 3 дахь удаагийн 10 жилийн стратеги юм. 1991 онд, Вьетнам улсын Коммунист Намын 7 дугаар Их хурлаар социализмд шилжин орох замаар улс орноо бүтээн байгуулах Хөтөлбөр гаргаж, 1991-2000-аад оны нийгэм, эдийн засгийн хөгжлийн анхны Стратегийг боловсруулан тодорхойлж, орчин үеийн аж үйлдвэржсэн нийгэм байгуулах эхлэлээ тавив. Вьетнам улсын Засгийн газар 5 жилийн төлөвлөгөө боловсруулан гаргахын зэрэгцээ Намын 7 дугаар Их хурлаар анхны 10 жилийн стратегийг гаргасан нь 2000 он хүртэлхи улс орны нийгэм, эдийн засгийг тогтворжуулан хөгжүүлэх Стратеги гэж тодорхойлсон байв<sup>3</sup>. Намын 9 дүгээр Их хурлаар гаргасан 2001-2010-аад оны Нийгэм, Эдийн засгийн хөгжлийн Стратегийн хэрэгжилтийн үр дүнд Вьетнам улс орчин үеийн аж үйлдвэржсэн улс орны нэгэн болох зорилтын хүрээнд хэд хэдэн чухал бөгөөд томоохон амжилтанд хүрч чаджээ. Хэдийгээр тус Стратегийн хэрэгжилтийн явцын хоёр заагт эдийн засгийн их хямралууд (1997-1998 оны Азийн бүсийн эдийн засгийн хямрал, 2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал) таарсан боловч өнгөрсөн 10 жилд Вьетнам улсын ДНБ-ний жилийн дундаж 7,23% байсан бөгөөд энэ нь тус бүсийн улс орнуудын дундаас хамгийн өндөр үзүүлэлт байв. ДНБ өсөлт ба инфляцийн түвшингийн хоорондын тэнцвэрт байдлыг дараахи хүснэгтээс авч харцгаая. 1996-2003 онуудад ДНБ-ний жилийн дундаж өсөлт 7,29%, инфляцийн өсөлт 3,03%, ДНБ ба инфляцийн өсөлтийн хоорондын хамаарал 41,6 хувьтай тэнцүү байна. Уг жилүүдэд хөрөнгө оруулалтын үр ашиг дараахи байдалтай байна: хөрөнгө оруулалт ба ДНБ-ний харьцаа 35 хувьтай тэнцэж, ICOR коэффициент 4,8 дахин өссөн, ДНБ-ийг 1 донгоор өсгөхөд 2,90 донгийн хөрөнгө оруулалт ногдож байжээ. 2004-2010 онуудад ДНБ-ний жилийн дундаж өсөлт 7,33%, инфляцийн өсөлт 10,67%, ДНБ ба инфляцийн өсөлтийн хоорондын хамаарал 145,6 хувьтай тэнцүү байна. Энэ хугацаанд хөрөнгө оруулалтын үр ашиг дараахи байдалтай байна: нийт хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь дунджаар 42,4 хувь болж өссөн, ICOR коэффициент 5,8 дахин өссөн, ДНБ-ийг 1 донгоор өсгөхөд 2,2 донгоос илүүгүй хөрөнгө оруулжээ. Энэхүү жилүүдэд хөрөнгө оруулалтын үр шим урдны жилүүдээс доогуур төвшинтэй гарч, инфляцийн түвшин ДНБ-ний өсөлтөөс хэт их өндөр байгаа тул ДНБ ба инфляци хоорондын харьцаа тогтворгүй байна<sup>4</sup>.



Эх сурвалж: Вьетнамын эдийн засгийн тойм сонин, *baotinh te Thoi bao Viet Nam*, №14, х.5

2001-2005 жилүүдэд ДНБ-ний жилийн дундаж өсөлт 7,5%, 2006-2007 онуудад тус үзүүлэлт 8-аас дээшээ хувьтай байв. 2008-2010 онуудад дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын улсаас ДНБ-ний дундаж өсөлт 5,96 хувьтай байлаа. Сүүлийн 5 жилийн дундаж (2006-2010) 7 хувь, сүүлийн 10 жилийн ДНБ-ний дундаж (2001-2010) 7,26 хувьтай байж 10 жилийн Стратегийн үндсэн зорилтыг амжилттай биелүүлж чадсан юм. Үүнийг дагаад нэг хүнд оногдох дундаж орлого нэмэгдсэн. Хөрөнгө оруулалт, Төлөвлөлтийн Яамнаас гаргасан статистикийн мэдээнээс үзэхэд, 90 оны эхний жилүүдэд нэг хүнд оногдох жилийн дундаж 86 ам.доллар, 1995 онд 289 ам.доллар байж, хүн амд ноогдох орлогын түвшингээр хамгийн бага орлоготой улс орны тоонд багтана, энэхүү үзүүлэлтээр Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн орлогын дундаж 34,7%-тай тэнцэж, тус бүсийн улс орнуудын 10/10-т, Азийн улс орнууд болон бүс нутгийн 43/49-т, дэлхийн улс орон болон бүс нутгийн 155/177 орж байсан бол 2008 онд Вьетнам улсын нэг хүнд оногдох дундаж орлогын хэмжээ 1000 гаруй ам.доллар, 2010 онд 1.168 ам.долларт хүрч Вьетнам улс дундаж орлогтой улс орны ангилалд багтаж томоохон амжилтанд хүрч чаджээ. Энэ үзүүлэлтээрээ Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн орлогын дундаж 43%-тай тэнцэж, тус бүсийн улс орнуудын 7/2011-т, Азийн улс орнууд болон бүс нутгийн 34/49-т, Азийн улс орнууд болон бүс нутгийн орлогын дундаж 26%-тай тэнцэж, дэлхийн улс орон болон бүс нутгийн 138/182 орж, орлогын дундаж 12%-тай тэнцэж байна<sup>5</sup>.

Статистик тоон үзүүлэлтийг авч үзвэл, 2010 онд Вьетнамын экспортын нийт эргэлтийн хэмжээ 71,6 тэрбум ам.долларт хүрч, ДНБ-ний 2/3 эзэлж, 2000 оноос 5 дахин илүү үзүүлэлт (14,5 тэрбум ам.доллар)

юм. Экспортын өсөлт нь Вьетнам орны хувьд эдийн засгийн хамгийн чухал хүчин зүйл бөгөөд энэхүү өсөлт дэлхийн зах зээлд гаргаж буй Вьетнамын экспортын бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Сүлжмэл эдлэлийн барааны экспорт Вьетнамын экспортын нийт эргэлтэнд гол хувь нэмэр оруулсаар байна (2010 онд 11,2 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оныхоос 23,2% өсч, экспортын нийт эргэлтийн 15,5% эзэлжээ). 2009 онтой харьцуулбал, Вьетнам улс 2010 онд экспортын эргэлтээр 1 тэрбум ам.доллараас давсан 5 төрлийн бараа бүтээгдэхүүнийг шинээр бүртгэж нийт 18 төрлийн бараа бүтээгдэхүүн болон нэмэгджээ. Үүнд бүх төрлийн бензин шатахуун, тос тосолгооны бүтээгдэхүүн, шингэн бодис агуулсан бараа бүтээгдэхүүн, цахилгаан утас, кабель, машин тээврийн хэрэгсэл зэрэг орж байна<sup>6</sup>.

Дээрхи амжилтанд хүрэхэд хэд хэдэн хүчин зүйлүүд нөлөөлсөн гэж үзэж байна, үүнд Вьетнам улс өөрийн эдийн засгийн давуу талуудыг зөв тодорхойлон хэрэгжүүлсэн, хүн ам зүйн өсөлтийн өнөөгийн байдлыг зөв, зохистой хувиарлаж, хөдөлмөрийн хөлсний хэмжээ харьцангуй бага, ажлын мэргэжлийн боловсон хүчин хангалттай, байгалийн эрдэс баялаг ихтэй, газар зүйн ашигтай байрлал, улс төрийн тогтвортой байдал, зах зээл, эдийн засгийн бүрэн ашиглаагүй нөөц боломжууд ихтэй зэрэг. Түүнчлэн, хоёр талын болон олон улсаас үзүүлж буй Хөгжлийн албан ёсны тусалцааг (ODA) Вьетнам улс сүүлийн хэдэн арван жил тасралгүй авсаар ирсэн. Жишээлбэл 2010 онд Япон Улсын Засгийн газраас Вьетнам улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд, тэр дундаа дэд бүтцийн хөгжилд зориулан 58,18 тэрбум иений буюу 700 гаруй сая ам.долларын Хөгжлийн албан ёсны тусалцааг Вьетнамын Засгийн газарт олгосон байна.<sup>7</sup> 1993 оноос 2008 он хүртэл Өмнөд Солонгосын Засгийн газар 90 сая ам.долларын хөрөнгийн буцалтгүй тусламж үзүүлж, 680 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгожээ. Өмнөд Солонгосын Засгийн газар 2008 оноос эдүгээ Вьетнамын Засгийн газарт 17,5 сая ам.долларын хөрөнгийн буцалтгүй тусламж олгож, 2008–2011 онд 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох тухай хэлэлцээрийг хоёр тал үзэглэсэн байна<sup>8</sup>.

2011 оноос эхлэн Хөрөнгө оруулалт, Төлөвлөлтийн Яам гадаадын хөрөнгө оруулалтыг улам чанаржуулах зорилгоор голчлон дэд бүтцийн төсөл, экологийн цэвэр, өндөр технологид тулгуурласан өрсөлдөх чадвартай бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төслүүдэд нэвтрүүлэхэд гадаад шууд хөрөнгө оруулалтыг чиглүүлэхээр шийдвэрлэсэн байгаа. Вьетнам улсын эдийн засгийн цаашдын урт хугацааны тогтвортой хөгжлийн амжилтын гол түлхүүр нь үйлдвэрлэлийн өртөг хямдхан бараа бүтээгдэхүүний экспортоос зардал өндөртэй, нэн ялангуяа шинэ технологид тулгуурлан үйлдвэрлэгдсэн

бараа бүтээгдэхүүний экспорт руу шилжих шилжилт байж болно гэсэн дүгнэлтэд хүрч байна. Ийнхүү, 2020 онд гэхэд Вьетнам улс хөдөө аж ахуйн улс орноос орчин үеийн аж үйлдвэржсэн улс орны нэгэн болох, Вьетнам улсын нэг хүнд оногдох жилийн дундаж 2010 оны үзүүлэлтээс 2,6 дахин илүү, хамгийн багадаа 3.036 ам.долларт хүргэх, жилдээ 10,1%-иар өсгөх зорилт тавин ажиллана гэдгээ 2011-2020-аад оны Нийгэм, Эдийн засгийн хөгжлийн Стратегид тусгажээ<sup>9</sup>.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД

*Вьетнам хэлээр:*

1. Хөрөнгө оруулалт сэтгүүл, tap chi Dau Tu, №13+14+15+16+17, х.26-27, х.29, х.30
2. <http://trungtamwto.vn/> Вьетнамын Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх ДХБ-ын Судлалын Төв
3. Вьетнамын эдийн засгийн тойм сэтгүүл, tap chi Thoi bao Kinh te Viet Nam, №25-32, х.8
4. Вьетнамын эдийн засгийн тойм сонин, bao Kinh te Thoi bao Viet Nam, №14, х.5
5. Вьетнамын эдийн засгийн тойм сэтгүүл, tap chi Thoi bao Kinh te Viet Nam, №25-32, х.31
6. Вьетнамын эдийн засгийн тойм сэтгүүл, tap chi Thoi bao Kinh te Viet Nam, №25-32, х.33
7. Хөрөнгө оруулалт сонин, Bao Dau Tu, №10 (2213), х.4
8. <http://vnexpress.net/GL/Kinh-doanh/2009/10/3BA14C81/>
9. Хөрөнгө оруулалт сонин, Bao Dau Tu, №09 (2122), х.4